

**ЛИБЕРАЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОЮУНЫ САНГИЙН ӨВӨРХАНГАЙ
АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА,
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ
ЗҮЙЛ ЗААЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН МОНИТОРИНГ**

**Арвайхээр хот
2014 он**

ГАРЧИГ

МОНИТОРИНГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА.....	3
МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД	3
МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ.....	4
МОНИТОРИНГИЙН ДҮН	5
ДҮГНЭЛТ	11
ЗӨВЛӨМЖ	12
НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	13

МОНИТОРИНГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Манай улс 2000 он хүртэл 10 гаруй жилийн хугацаанд жил бүр дотоодын нийт бүтээгдэхүүний бараг гуравны нэг хувьтай тэнцэхүйц мөнгийг бие даасан хуульгүйгээр төрийн худалдан авах үйл ажиллагаанд зарцуулж байжээ. Харин 2000 онд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох тухай” журам баталж, 2005 онд уг журмыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болгон мөрдсөн юм. Харин 2011 онд хуулийг өөрчлөн найруулж, 2012 оны 10-р сарын 1-ний өдрөөс даган мөрдөж байгаа билээ.

Ийнхүү хэдийгээр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авалт хийх эрхзүйн орчин бүрдээд 10 гаруй жил болж байгаа ч орон нутагт худалдан авах ажиллагаатай холбоотой төсвийн үргүй зардал буурахгүй хэвээр байна. Тиймээс төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн хэрэгжилт орон нутагт ямар байгаад мониторинг хийх замаар хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, улмаар хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах хэрэгцээ, шаардлага байгаа юм. Үүнийг харгалзан Либерал эмэгтэйчүүдийн оюуны сангийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлөөс Нээлттэй Нийгэм Форумын Мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн зарим заалтууд тус аймагт хэрхэн хэрэгжиж байгаад мониторинг хийсэн болно.

МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Зорилго: “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн худалдан авах ажиллагааг төлөвлөх, тендерийн баримт бичиг бэлтгэх, тендерийг хянан үзэх, үнэлэх болон худалдан авах ажиллагааны зарчмуудыг тодорхойлсон заалтууд Өвөрхангай аймагт хэрхэн хэрэгжиж байгаад мониторинг хийх.

Зорилтууд:

1. Худалдан авах ажиллагааг төлөвлөх тухай 48.1-5 дахь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
2. Тендерийн баримт бичиг бэлтгэх тухай 47.2.1, 19.1-2 дахь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
3. Тендерийг хянан үзэх ба үнэлэх тухай 27.2, 28.3 дахь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
4. Тендерийн гүйцэтгэл буюу гэрээний хэрэгжилтэд хяналт тавих тухай 46.1.6 дахь заалтад мониторинг хийх
5. Худалдан авах ажиллагааны зарчим буюу 6.1 дэх заалтад дурдсан дөрвөн үе шатад хэрэгжиж байгаа эсэхэд мониторинг хийх

МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

Мониторингийг 2013 оны 9-р сараас 2014 оны 2-р сар хүртэлх хугацаанд Өвөрхангай аймгийн Уянга болон Бүрд сумдад хэрэгжүүлсэн юм. Ингэхдээ, тендер нь 2008-2012 онуудад зарлагдаж, барилга угсралтын ажил нь эхэлсэн ч 2013 оны 9-р сарын байдлаар барилгын ажил дуусаагүй байсан дараах гурван объектыг сонгосон юм:

1. Уянга сумын 640 хүүхдийн ерөнхий боловсролын сургууль: Уг сургуулийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих тендер 2008 онд зарлагдаж, “Химон констракшн” ХХК 3 тэрбум 865 сая 500 мянган төгрөгийн өртгөөр гүйцэтгэхээр шалгарсан юм. Гэвч тус компанийн зүгээс төсөв хүрэлцэхгүй байна гэсэн шалтгаанаар барилгын ажлыг 80 хувийн гүйцэтгэлтэй байхад нь зогсоожээ.
2. Уянга сумын сайн ноён хан Намнансүрэнгийн музей: Музейн барилгыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барих тендер 2011 онд зарлагдаж, “Хархорин-өргөө” ХХК 229 сая төгрөгийн өртгөөр гүйцэтгэхээр шалгарсан юм. Гэвч тус ондоо барилын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байхад ажлаа зогсоосон байна.
3. Бүрд сумын Эрүүл мэндийн төв: Энэ төвийн барилга угсралтын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих тендер 2012 онд зарлагдаж, “Цагаан бургалтай” ХХК 447 сая 800 мянган төгрөгийн өртгөөр гүйцэтгэхээр шалгарсан юм. Тус компани нь барилгын ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байхад 2 дахь санхүүжилт орж ирээгүй гэсэн шалтгаанаар ажлаа зогсоожээ.

Барилга угсралтын ажлууд зогссоны улмаас дээрх гурван объект байгалийн нар, салхи, бороонд гандаж, чанараа алдах зэргээр гүйцэтгэлийн хувь нь буурах нөхцөл үүссэн юм. Худалдан авах ажлуудыг зохион байгуулсан үед 2005 онд батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль мөрдөгдөж байсан тул мониторингийн хүрээнд энэ хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийн тухай мэдээллийг цуглуулсан болно. Ингэхдээ мэдээлэл цуглуулах дараах аргуудыг ашигласан юм:

1. Баримт бичгийн судалгаа- Мониторингод хамруулсан гурван объектын тендерийг төлөвлөх, баримт бичгийг бэлтгэх, тендерийг хянан үзэх болон үнэлэх явцад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дээр дурдсан заалтуудыг хэрэгжүүлсэн эсэх талаар мэдээлэл цуглуулахын тулд холбогдох тендерийн хавтаст материал, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, үнэлгээний хорооны гишүүдийн үнэлгээний хуудас, аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсээс аймгийн Засаг даргад, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-аас Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт явуулсан албан бичиг зэргийг судалсан болно.
2. Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага- Дээр дурдсан гурван тендерийн үнэлгээний хорооны гишүүдтэй уулзаж, тэд тендерийн бичиг баримтыг боловсруулах, сонгон шалгаруулах хуралд оролцсон эсэх зэрэг хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн тухай асуусан юм. Түүнчлэн, орон нутгийн захиалагч байгууллагуудтай гурван удаагийн уулзалт хийж, тухайн тендерийн гүйцэтгэл, худалдан авах ажиллагааг зохион байгуулахад гардаг хүндрэл бэрхшээл, цаашид худалдан авах ажиллагааг хэрхэн сайжруулах талаар ярилцсан юм. Үүнээс гадна, тендерт оролцсон аж ахуйн нэгжүүдийн удирдлага,

ажилтнууд болон Уянга ба Бүрд сумын иргэдтэй тус бүр фокус бүлгийн ярилцлага хийх замаар мониторингод хамруулсан гурван объектын тендерийн хэрэгжилт, цаашид авах шаардлагатай арга хэмжээ, орон нутагт хийгдэж буй бүтээн байгуулалт, түүний чанар, үр дүнгийн талаар хэлэлцсэн болно.

3. Нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцах- Өвөрхангай аймгийн Бүрд, Уянга сумдад очиж, дээр дурдсан гурван худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн өнөөгийн нөхцөл байдалтай нь танилцан хэмжилт хийж, баримтжуулсан юм.

МОНИТОРИНГИЙН ДҮН

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг зохицуулсан 48.1, 48.2, 48.4, 48.5 дахь заалтын хэрэгжилт:

Уянга сумын ерөнхий боловсролын сургуулийн 640 хүүхдийн хичээлийн байрыг Боловсрол, соёл шинжлэх ухааны яамны захиалгаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж эхэлсэн юм. Энэхүү худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам барилгын зураг төсөл хийгээгүй, төсвийг нарийвчлан тооцож гаргаагүй байна. Сургуулийг барихад шаардлагатай мөнгийг 2008 онд Өвөрхангай аймгаас сонгогдсон Улсын их хурлын гишүүд тойрогтоо томоохон бүтээн байгуулалт хийх зорилгоор баримжаагаар улсын төсөвт тусгасан ажээ. Үүний улмаас барилгын ажил гүйцэтгэх явцад төсөв хөрөнгө нь хүрэлцэхгүй болж, ажил зогссон байна.

Өөрөөр хэлбэл, хуулийн 48.1 болон 48.5 дахь заалтууд зөрчигдөж, аймгийн Боловсрол, соёлын газраас Уянга суманд сургуулийн хичээлийн байр барих төлөвлөгөө явуулаагүй байхад Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Мөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2008 оны эхний сард хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан мэдээлэх ёстой байтал хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлсэн баримт, нотолгоо байхгүй байна. Түүнчлэн, хуулийн 48.2, 48.3, 48.4 дэх заалтууд зөрчигдсөн нь төсвийн ерөнхийлөн захирагч болох Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны сайд төлөвлөгөөг эцэслэн боловсруулж батлаагүй, хэрэгжилтэд нь хяналт тавиагүй, мөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

48.1: Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан боловсруулж улсын төсөв батлагдсанаас хойш 30 хоногийн дотор харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

48.2: Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн төсвийн хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг эцэслэн боловсруулж улсын төсөв батлагдсанаас хойш 45 хоногийн дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

48.3: Захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагч баталж хэрэгжилтэд нь хяналт тавина.

48.4: Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж үнэлгээ хийнэ.

48.5: Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн эхний сард хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

байгууллага болох Сангийн яам ч төлөвлөгөөнд хяналт тавьж, үнэлгээ хийгээгүйгээс барилгын ажил зогсож, хэрэглэгчдийн эрх ашиг зөрчигдсөн байна.

Уянга сумын Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн музейн барилгыг аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн захиалгын дагуу орон нутгийн төсвөөр барьж эхэлсэн ч, тус барилга 2011 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байжээ. Барилгын зураг төслийг 2011 онд төсөв нь батлагдсаны дараа хийсэн байна. Барилгын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байхад хөрөнгө мөнгө хүрэлцэхгүй байна гэсэн шалтгаанаар гүйцэтгэгч компанийн зүгээс орон нутгийн төсвөөс нэмж мөнгө нэхэмжлэн, ажлаа зогсоожээ. Мөн барилгын төсвийг анх зохиохдоо тус барилгыг цахилгаан халаагуураар халаахаар тусгасан аж. Гэвч зардлыг нь орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх боломжгүйг сумын удирдлагуудын зүгээс мэдэгдсэнээр барилгыг халаалтын шугамд холбохоор болж, нэмэлт 159 сая төгрөг шаардлагатай гэж тооцоолсон байна. Иймээс, орон нутгийн төсвөөс 100 сая төгрөг, гүйцэтгэгч “Хархорин өргөө” ХХК-аас 59 сая төгрөгийн төсөв гаргаж, асуудлыг шийдвэрлэхээр болжээ. Гэвч халаалт авах газар нь хол зайтай учраас нэмэлт санхүүжилтийн хэмжээ мөн л хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар өнөөдрийг хүртэл ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна. Дээрхээс харахад музейн тендерийн захиалагч болох аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа судалгаа, тооцоо хийгээгүйгээс гадна төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлснийг батлах баримт байхгүй байна. Түүнчлэн, төсвийн ерөнхийлөн захирагч болох аймгийн Засаг дарга төлөвлөгөөг эцэслэн боловсруулахдаа хайнга хандаж, хэрэгжилтэд нь хяналт тавиагүй, мөн Сангийн яам төлөвлөгөөнд хяналт тавьж, үнэлгээ хийгээгүй ажээ.

Бүрд сумын эрүүл мэндийн төвийн барилга нь 2012 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад ороогүй бөгөөд тухайн жил Улсын их хурлын гишүүдийн өөрсдөдөө хуваарилсан тэрбум төгрөгийн төсвөөс ямар ч зураг төсөлгүй, төсвийн тооцоогүйгээр баригдаж эхэлжээ. Эдгээр гишүүд 2012 оны сонгуулиар дахин сонгогдоогүй учраас эрүүл мэндийн төвийг барих санхүүжилтийг гүйцээж өгөөгүй байна. Энэ тендерийн тухайд хуулийн 48.1-48.5 дахь заалтууд бүгд зөрчигдсөн бөгөөд тендерийн захиалагч болох аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс, төсвийн ерөнхийлөн захирагч болох аймгийн Засаг дарга болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Сангийн яам дээрх заалтуудад тусгасан өөрсдийн үүргийг биелүүлээгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн тендерийн баримт бичгийн бэлтгэлийг зохицуулсан 47.2.1 болон 19.1-2 дэх заалтын хэрэгжилт:

Тендерийн баримт бичиг бэлтгэх, тендерийн урилга нийтлэх, олон нийтэд мэдээлэх ажлыг захиалагчийн байгуулсан үнэлгээний хороо хариуцан гүйцэтгэхээр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 47.1-47.2.1-д заасан юм. Энэхүү хороо сондгой тооны гишүүдтэй байх бөгөөд ихэвчлэн 5-7 гишүүнтэй байдаг ажээ.

Гэвч мониторингод хамруулсан гурван объектын үнэлгээний хорооны гишүүдтэй ярилцахад тэд тендерийн баримт бичиг боловсруулахад оролцоогүйгээ хэлсэн бөгөөд баримт бичгийг үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллах үүрэгтэй аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн ганцаараа боловсруулсан байна. Үнэлгээний хорооны гишүүдийн хэлж буйгаар тендерийн зар хэзээ, ямар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсныг мэдээгүй байхад л нэг өдөр тендерийн үнэлгээ хийх болсныг дуулгаж, тэд нарыг дууддаг гэнэ. Тендерийн баримт бичиг боловсруулах тухай бид мэддэггүй гэж хэллээ.

Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн тендерийн баримт бичиг боловсруулахдаа холбогдох зааварчилгаа болох тендерийн жишиг баримт бичгийг мөрдөж боловсруулсан хэдий ч судалгаа шинжилгээ огт хийлгүйгээр, жишиг баримт бичгийг тэр чигээр нь хуулаад нөхөж бичсэн байна.

Гурван объектын тендерийн баримт бичгээс харахад тендерт оролцогчдод тавьж буй шалгууруудыг тодорхой бус, ойлгомжгүй байдлаар томъёолсон төдийгүй захиалагчийн санал болгож буй техникийн тодорхойлолт нь салаа утгатай, мөн Бүрд сумын Эрүүл мэндийн төв болон Уянга сумын музейн барилгын хувьд барилгын зургийг тендерийн баримт бичигт хавсаргаагүй орхигдуулах зэрэг зөрчлүүд гарсан байна.

47.2.1: [Үнэлгээний хороо нь] техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэнэ.

19.1: Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ.

19.2: Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн тендерийг хянан үзэх ба үнэлэх тухай 27.2 болон 28.3 дахь заалтын хэрэгжилт:

Мониторингод хамруулсан гурван худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны дийлэнх гишүүд нь тендерийг сонгон шалгаруулах хуралд оролцоогүй ажээ. Тухайлбал, Уянга сумын музейн барилгын тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны 7 гишүүнээс 4 гишүүн нь нэг ч удаагийн хуралд оролцоогүй, Бүрд сумын эрүүл мэндийн төвийн барилгын тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны 7 гишүүнээс 5 нь мөн хуралд оролцоогүйг эдгээр үнэлгээний хороодын хурлын тэмдэглэл харуулж байна.

27.2: [Үнэлгээний хороо] тендерийг хянахдаа бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд үзүүлэх сөрөг нөлөө, захиалагчийн санал болгосон гэрээний нөхцөлд хуульд үл нийцэх хязгаарлалт оруулсан эсэх, шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх эсэх зэргийг хянан үзнэ.

28.3: Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна.

Гурван барилга угсралтын ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа захиалагч нь барилгын зураг төсөл, төсөв, техник эдийн засгийн үндэслэл зэргийг бүрэн дүүрэн тусгаагүй учраас тендерт оролцогчид саналаа ирүүлэхдээ барилгын чанар болон гүйцэтгэлд үзүүлэх сөрөг нөлөө зэрэг чухал мэдээллийг мөн орхигдуулсан байна. Тухайлбал, тендерт шалгарсан компани Уянга сумын сургуулийн барилга барих газрын хөрсний болон геологийн судалгаа шинжилгээ хийгээгүй тул сургуулийн байрыг цэвдэгтэй газар барьсан юм. Энэ нь барилга угсралтын ажлын чанар болон гүйцэтгэлийн эцсийн үр дүнд сөрөг үр дагавар бий болоход нөлөөлжээ. Тендерийг хянан үзсэн үнэлгээний хороо тендерт оролцогчийг шалгаруулахдаа тухайн оролцогч хуулийн 27.2-т дурдсан шаардлагыг биелүүлж буй эсэхэд хяналт тавьж ажиллаагүйг мөн дээрх жишээ харуулж байна.

Хэдийгээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 28.3-т тендерийн үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна гэж заасан байдаг ч энэхүү заалт нь хамгийн бага үнэтэй тендерийг шалгаруулах тухай бус, харин захиалагчийн тавьсан шаардлагад бүрэн нийцсэн, бага үнэтэй тендерийг шалгаруулах тухай билээ. Гэтэл Уянга сумын музейн барилга, Бүрд сумын эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлын тендерүүдийг үнэлэхдээ захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн эсэхийг сайн нягтлахаас илүүтэйгээр хамгийн бага үнийг нь харж, сонгон шалгаруулалт хийсэн байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн тендерийн гүйцэтгэл буюу гэрээний хэрэгжилтэд хяналт тавих тухай 46.1.6 дахь заалтын хэрэгжилт:

46.1.6: Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавина.

Тендерийн гүйцэтгэлд хяналт тавих асуудлыг захиалагч ба гүйцэтгэгч хоорондын гүйцэтгэлийн гэрээгээр зохицуулдаг ажээ. Мониторингод хамруулсан гурван худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн гэрээнд захиалагч болон гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлагын талаар тойм төдий тусгасан бөгөөд гэрээний хэрэгжилтийг огт дүгнээгүй

байна. Жишээлбэл, Бүрд сумын эрүүл мэндийн төвийн барилгын гүйцэтгэлийн гэрээнд хяналт, хариуцлагын талаар ямар нэгэн зүйл заалт огт тусгаагүй байна. Үүний улмаас өнөөдрийг хүртэл барьж дуусаагүй энэхүү барилгын гүйцэтгэгч “Цагаан бургалтай” ХХК ямар нэгэн хариуцлага хүлээгээгүй төдийгүй өөр тендерт удаа дараа оролцсоныг мониторингийн явцад тогтоосон юм. Тухайн үед хүчин төгөлдөр хэрэгжиж байсан хуулинд гүйцэтгэгчтэй хариуцлага тооцох талаар тоймтой зүйл заалт тусгаагүй байсан нь ийм үр дагаварт хүргэсэн гэж хэлж болно.


Уянга сумын ерөнхий боловсролын сургууль болон сайн ноён хан Намнансүрэнгийн музейн барилгын тухайд нөхцөл байдал мөн адилхан байна. Барилгын явц удаашрах, барилгыг тендерийн баримт бичигт зааснаас өөр үзүүлэлттэй материалаар барих зэрэг алдаа дутагдлууд илэрсэн нь эдгээр худалдан авах ажиллагааны захиалагч байгууллагуудын зүгээс тавих хяналт сул байсныг мөн харуулж байна. Захиалагч болох Боловсролын яам, Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар, Барилга хот байгуулалтын газраас гадна Мэргэжлийн хяналтын газар, тухайн орон нутгийн удирдлага зэрэг холбогдох бусад субъект огт хяналт тавьдаггүй байсан нь мониторингийн явцад харагдсан юм. Тухайлбал, Уянга сумын сургуулийн захиралтай ярилцаж байхад тэрээр сургуулийн тендерийн гүйцэтгэл ямар шалтгааны улмаас зогсонги байдалд орсон талаар мэдэхийг хүсэхгүй, баригдаж байгаа сургууль “манай” сургууль гэсэн сэтгэл байхгүй нь илт байлаа:

“Энэ сургууль баригдахгүй удаж байна, учир нь хаанаа, хэндээ байгааг ойлгох юм алга, дээгүүрээ л ямар нэг хувилдаан зохион байгуулсан байх.”

Уянга сумын сургуулийн захирлын ярианаас

Тендерийн гүйцэтгэлийн хяналт сул байсан нь тухайн үед хүчин төгөлдөр хэрэгжиж байсан хуулиар тендер зохион байгуулах эрхийг орон нутагт шилжүүлдэггүй байсантай мөн холбоотой ажээ. Үүний улмаас холбогдох яамнаас зарласан тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүд тухайн аймаг, орон нутгийн удирдлагуудын зүгээс тендерийн гүйцэтгэлд шаардлага тавихад “Бид та нартай гэрээ хийгээгүй болохоор та нарт хамаагүй” хэмээн тоодоггүй, тавьсан шаардлагыг нь биелүүлдэггүй байсан юм.¹

¹ 2011 оны 6 сарын 9-ний өдөр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд 45.6, 7.1 дэх заалтуудыг тус тус нэмж тусгасанаар тухайн орон нутаг худалдан авах ажиллагаагаа өөрсдөө зохион байгуулж, хяналт тавьдаг болсон юм.



Өвөрхангай аймгийн Уянга суманд 2008 онд баригдаж эхэлсэн ерөнхий боловсролын сургуулийн барилгын ажил зогсонги байдалд орж, 2013 оны 10 сарын байдлаар сууриасаа дээвэр хүртэл цууралт өгч нурахад бэлэн болсон байна.



2012 онд Өвөрхангай аймгийн Бүрд суманд баригдаж эхэлсэн эрүүл мэндийн төвийн барилга 2013 оны 10 сарын байдлаар эзэнгүйдэж, нар, салхинд элэгдэж, барилгын гүйцэтгэл 30-20% болтлоо тоногдсон байна.



Т.Намнансүрэнгийн музейн барилгын гүйцэтгэл тухайн үед 60%-ийн гүйцэтгэлтэй зогссон ч одоогийн байдлаар гүйцэтгэл нь 40% болтлоо буурчээ. 2013 оны 10 сарын байдлаар музейн дээврийн төмөр нь ховхрон урагдаж, салхинд хийссэн бөгөөд хаалганы онгорхойг том модоор дарж хаасан байна. Барилгын дотор хураасан дүүжин тааз, хаалга зэрэг барилгын аар саар материалууд борооны усанд норж өмхийрчээ.

Худалдан авах ажиллагаа ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмын хэрэгжилт:

Ил тод байх зарчмын хэрэгжилт:

Мониторингод хамруулсан гурван барилга угсралтын ажлын хувьд худалдан авах ажиллагааны зохион байгуулалт ил тод бус байсан юм. Дээр дурдсанчлан, эдгээр худалдан

авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүйгээс гадна тендерийн баримт бичиг боловсруулах, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг шалгаруулах, тендерийн гүйцэтгэлд хяналт тавих зэрэг бүх үйл явц нь

6.1: Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

хаагдмал орчинд явагдсан нь мониторингийн хүрээнд судалсан баримт бичиг болон холбогдох талуудтай хийсэн ярилцлагууд харуулж байна.

Өрсөлдөх тэгш боломжтой байх зарчмын хэрэгжилт:

Гурван тендерийн баримт бичгийг судлахад, тендерт оролцогчдод тавьсан шалгууруудыг тодорхой бус, ойлгомжгүй байдлаар томъёолсон, захиалагчийн санал болгосон техникийн тодорхойлолт нь салаа утгатай байсан зэрэг нь өрсөлдөх тэгш боломжийг боогдуулсан үйлдэл болсон гэж хэлж болно. Түүнчлэн, аж ахуйн нэгжүүдийн төлөөллүүдийн ярьж буйгаар 2008-2011 онуудад Өвөрхангай аймагт орон нутгийн ойн арга хэмжээ, баяр наадмын зардал зэрэгт хэр хэмжээний хандив өгснөөс хамаарч аж ахуйн нэгжүүдэд тендер хуваарилдаг байжээ. Ямар нэг хандив өгөөгүй бол тендерт оролцсон ч ялах магадлал бага байсан нь өрсөлдөх тэгш боломжтой байх тухай зарчим төдийлөн хэрэгжихгүй байсныг нотолж байна.

Үр ашигтай байх зарчмын хэрэгжилт:

Зорилтод гурван барилга угсралтын ажлын хувьд үр ашигтай байх зарчим огт хэрэгжээгүй, харин ч төсвийн мөнгийг төлөвлөлтгүй, эрсдэлийг тооцолгүй, үр ашиггүй зарцуулсан гэдэг нь мониторингоос тодорхой харагдаж байна. Тендерийг зураг төсөлгүй, төсвийн тооцоо, эдийн засгийн үр ашигтай байдлыг нь харгалзан төлөвлөөгүйгээс барилгын ажил олон жил дамжин үргэлжилж, эцэст нь хагас дутуу барьсан байшин барилгууд балгас болон хувирч байгаа нь тендер үр ашигтай байх зарчим хэрэгжээгүйг харуулж байна.

Хэмнэлттэй байх зарчмын хэрэгжилт:

Гурван барилга угсралтын ажлын тухайд хамгийн бага үнэтэй саналыг шалгаруулснаар тендер хэмнэлттэй байх зарчим хэрэгжээгүй юм. Харин ч захиалагчийн тавьсан шаардлагаас илүүтэй тендерийн үнийн асуудалд илүү ач холбогдол өгсөн нь тендерийн гүйцэтгэл болон эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлжээ.

Хариуцлагатай байх зарчмын хэрэгжилт:

Худалдан авах ажиллагааны хариуцлагатай байх зарчим тендерийг төлөвлөх, баримт бичиг боловсруулах, тендерийг сонгон шалгаруулах болон гэрээний гүйцэтгэлд хяналт тавих зэрэг мониторингод хамруулсан бүх шатанд огт хэрэгжээгүй байна. Дээр дурдсанчлан, барилгын ажлыг зураг төсөлгүйгээр, төсвийн бодит тооцоо гаргаагүйгээр эхлүүлснээс гадна тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийг сонгон шалгаруулахад үнэлгээний хорооны гишүүд оролцоогүй, ажил гүйцэтгэх гэрээнд хариуцлага тооцох талаар тусгаагүй, захиалагчийн зүгээс гүйцэтгэлд хяналт тавиагүй зэрэг бүх шатанд хариуцлагатай байх зарчим зөрчигдсөн байна.

ДҮГНЭЛТ

Өвөрхангай аймгийн Уянга болон Бүрд суманд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн худалдан авах ажиллагааг төлөвлөх, тендерийн баримт бичиг бэлтгэх, тендерийг хянан үзэх, үнэлэх болон худалдан авах ажиллагааны зарчмуудыг тодорхойлсон заалтуудын хэрэгжилт мониторингод хамруулсан гурван объектын тухайд хангалтгүй байна:

- Худалдан авах ажиллагааг төлөвлөх ажлын хүрээнд захиалагч нь хуульд зааснаар барилгын зураг төсөл болон төсвийн төслийг огт хийхгүй эсхүл шаардлага хангахуйц хэмжээнд хийхгүй байх зөрчил гарсан байна. Үүний үр

дүнд гүйцэтгэлийн явцад санхүүжилт хүрэлцэхгүй болох эсхүл барилга угсралтын ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах шаардлага гарч, барилгын ажил удаан хугацаанд зогсох тохиолдол олонтаа гарчээ. Ингэснээр, худалдан авах ажиллагаа үр ашиггүй, үр дүнгүй болсон байна.

- Тендерийн баримт бичгүүдийг хуульд зааснаар үнэлгээний хорооны гишүүд боловсруулах ёстой байтал тус хорооны нарийн бичгийн дарга дангаараа боловсруулсан байна. Үүний улмаас техникийн тодорхойлолт, тендерт оролцогчдод тавих шаардлага, тендерийн шалгуур үзүүлэлтүүд, аргачлал ба санал болгож буй гэрээний нөхцөлүүдийг алдаатай эсхүл хэн нэгэнд давуу эрх олгосон байдлаар боловсруулж, улмаар өрсөлдөх тэгш боломжийг хаах зэрэг нөхцөлийг бий болгосон байна.
- Тендерийг сонгон шалгаруулах явцад үнэлгээний хорооны гишүүд мөн оролцохгүй байх тохиолдол нэлээдгүй гарсан нь гүйцэтгэгчийг буруу сонгох, аль нэг оролцогч талд давуу байдал үүсгэх зэрэг нөхцөлийг бүрдүүлжээ. Түүнчлэн, сонгон шалгаруулалт хийхдээ үнэлгээний хорооны гишүүд худалдан авах бараа, ажил үйлчилгээний чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай хүчин зүйлс байгаа эсэхийг хянаж үзээгүйгээс худалдан авах ажиллагаа үр ашиггүй, үр дүнгүй болоход нөлөөлсөн байна.
- Барилгын ажлын гүйцэтгэлд захиалагчийн зүгээс тавьж буй хяналт сул, захиалагч болон гүйцэтгэгчийн хооронд байгуулдаг гэрээнд хариуцлага тооцох асуудал тусгагдаагүй байна. Үүний улмаас барилгыг тендерийн баримт бичигт зааснаас өөр үзүүлэлттэй материалаар барих, гүйцэтгэгч компани ямар ч хариуцлага хүлээхгүй байгаагаас гадна өөр тендерт удаа дараа оролцсон тохиолдлууд гарчээ.
- Ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зэрэг худалдан авах ажиллагаанд баримтлах ёстой таван зарчим хэрэгжээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

- Захиалагч нь худалдан авах ажиллагааг төлөвлөх явцад хуульд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төсвийн тооцоо болон зураг төслийг боловсруулж, олон нийтэд мэдээлж байх.
- Тендерийн баримт бичиг боловсруулах ажлыг дан ганц үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга гүйцэтгэж байгааг таслан зогсоож, энэ ажилд үнэлгээний хорооны гишүүдийг тэгш эрхтэй, бүрэн оролцуулж байх нөхцөлийг тусгасан журам боловсруулах, үүнд төсвийн ерөнхийлөн захирагч болон захиалагч байгууллагууд анхаарч ажиллах.
- Тендерийг сонгон шалгаруулах явцад үнэлгээний хорооны бүх гишүүд заавал оролцож, хуульд тусгасан шалгуурын дагуу тендерийг үнэлдэг байх шаардлагыг мөн дээрх журамд тусгаж, биелэлтэд нь хяналт тавих.

- Журамд, үнэлгээний хорооны гишүүдийг урамшуулах замаар тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийг сонгон шалгаруулах явц дахь тэдний идэвхтэй, бодит оролцоог нэмэгдүүлэх тухай тусгах.
- Захиалагч ба гүйцэтгэгч хоорондын ажил гүйцэтгэх гэрээнд ажлыг хугацаанд нь дуусгах, дуусгаж чадаагүй тохиолдолд тухайн ахуйн нэгжид алданги тооцож байх. Мөн гэрээний гүйцэтгэлд хэн, хэрхэн хяналт тавих болон хариуцлага алдсан тохиолдолд хэрхэн арга хэмжээ авах асуудлыг нарийвчлан тусгаж байх.
- Худалдан авах ажиллагааны бүхий л явцад ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмуудыг баримтлах талаар төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхий менежерүүд, шат шатны Засаг даргын Тамгын газрууд анхаарч ажиллах.

НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мониторингод хамруулсан гурван объектын худалдан авах ажиллагааны гажуудлын талаар телевизийн сурвалжлага, сонингийн нийтлэл бэлтгэн, олон нийтэд хүргэсэн болно. Мөн уг асуудалд хамааралтай бүх талуудыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох албан тушаалтнуудад хандаж барилгын ажлыг дуусгахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлээ.

Энэ хүрээнд Өвөрхангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ)-ын дарга Г.Ганболдод мониторингод хамруулсан 3 барилгын өнөөгийн нөхцөл байдлыг танилцуулсан, барилгын ажлыг дуусгахыг шаардсан албан бичиг хүргүүлсэн юм. Үүний үр дүнд ИТХ-ын дарга Г.Ганболд аймгийн Засаг дарга Д.Тогтохсүрэнд үүрэг өгснөөр Уянга сумын музейн барилга болон Бүрд сумын эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлуудыг хийж дуусгахад шаардлагатай төсвийг 2014 оны орон нутгийн төсөвт тусгасан билээ. Мөн Уянга сумын хүүхдийн хичээлийн байрыг барьж дуусгахад шаардлагатай хөрөнгийг 2014 оны улсын төсөвт тусгах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд саналыг 2014 оны төсөв хэлэлцэхэд дэмжсэн байна.

Түүнчлэн, аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Худалдан авах ажиллагааны албаны дарга Ч.Гүнсэнхоролд хүргүүлсэн албан бичигт тендерийн баримт бичгийг үнэлгээний хорооны гишүүдийн оролцоотойгоор боловсруулж байх талаар шаардлага тавьсны үр дүнд энэ асуудалд анхаарч ажиллахаа мэдэгдэж, улмаар 2014 он гарсаар Өвөрхангай аймагт хийгдэж буй бүх худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг үнэлгээний хорооны гишүүдийн оролцоотойгоор боловсруулж байна.

Мөн Арвайхээр сумын ИТХ-ын дарга Н.Ганбаттай орон нутагт хийгдэж байгаа бүтээн байгуулалт, төсөл, арга хэмжээ болон хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд өдөр тутмын хяналт тавих ажлыг орон нутгийн иргэдээр гүйцэтгүүлж байх талаар санал солилцож, албан бичиг хүргүүлсэн болно. Үүний үр дүнд орон нутагт хийгдэж байгаа аливаа хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд орон нутгийн иргэд хяналт тавих тухай журам боловсруулж, 2014 оноос эхлээд мөрдөж байна.